

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-9

---

*1. Байнгын хорооны даргыг сонгох тухай* 3-6

*2. “Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл* 6-9

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны  
10 дугаар сарын 11-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 28 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Н.Учрал;  
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Дэлгэрсайхан, Х.Нямбаатар;  
Тасалсан: Д.Ганбат, Б.Пүрэвдорж.

**Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

**Ц.Мөнх-Оргил:** Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 0  
Бүгд: 10  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.“Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил “Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Бямбацогт, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

**Ц.Мөнх-Оргил:** “Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 1  
Бүгд: 10  
90.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 24 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 52 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
12 цаг 28 минут.

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ц.Мөнх-Оргил:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. ХЗБХ-ны 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Ирц танилцуулъя. Ирц бүрдсэн байна. Бат-Амгалан гишүүн ирсэн байна, Мөнхбаатар гишүүн ирсэн байна, Мөнх-Оргил ирсэн байна, Мөнхцэцэг гишүүн ирсэн байна, Раднаасэд гишүүн ирсэн байна, Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Сүхбаатар гишүүн ирсэн байна, Сэргэлэн гишүүн ирсэн байна, Цогтбаатар гишүүн ирсэн байна, Б.Энх-Амгалан гишүүн ирсэн байна. Хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэнэ. Нэгд Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудал, 2-т Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн 2 асуулт байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудлаа баталъя. Хэлэлцэх асуудалдаа оръё.

#### **Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудал хэлэлцье. Улсын Их Хурлын тухай хуулийн 26.3-д Байнгын хороог Улсын Их Хурлаас нэг жилийн хугацаагаар сонгосон дарга тэргүүлнэ. 26.4-д Байнгын хорооны даргыг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршилагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээ сонгох бөгөөд түүнийг

улируулан сонгож болно гэж заасан байгаа. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн танилцуулна.

#### **Д.Тогтохсүрэн:**

ХЗБХ-ны гишүүддээ өдрийн амгаланг айлтгая. ХЗБХ-ны даргаар ажиллаж байгаа Баттөмөрийн Энхбаяр гишүүн Засгийн газрын гишүүн, ХЗДХ-ийн сайд болсон. Үүнтэй холбогдуулаад ХЗБХ-ны даргыг чөлөөлж, шинэ дарга сонгох ийм шаардлага үүссэн. Улсын Их Хурал дахь олонхын бүлэг ХЗБХ-ны даргад Улсын Их Хурлын гишүүн, ХЗБХ-ны гишүүн Дамдины Цогтбаатарын нэрийг дэвшүүлж байна.

Дамдины Цогтбаатар 1970 онд төрсөн, Улаанбаатар хотод төрсөн, 53 настай, эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. 88 онд Монгол Оросын хамтарсан 14 дүгээр сургууль, 94 онд ОХУ-ын Москва хотын Олон улсын харилцааны дээд сургууль, 98 онд Австралийн Үндэсний Их сургууль тус тус төгссөн. 94 оноос 2000 он хүртэл Гадаад харилцааны яаманд ажилласан. 2002-оос 2008 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх, 2008-аас 11 онд Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, ингээд 2011-ээс 12 онд Ерөнхий сайдын зөвлөх, 12 оноос ЗГ-ын гишүүн, Байгаль орчны сайд, 14-өөс 15 онд ЗГ-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд, 2017 оноос ЗГ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд, 17-гоос 20 онд, 16 оноос Улсын Их Хурлын гишүүн, 20 оноос Улсын Их Хурлын гишүүн, 16 оноос Монгол Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны даргаар, одоо Хууль зүйн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын бүлгийн даргаар ажиллаж байгаа. Орос, англи, герман, кхмер нэр хэлтэй. Ийм төрийн бэлтгэгдсэн, парламентын гишүүнээр 2 удаа, ЗГ-ын гишүүнээр 3 удаа

ажилласан, бас Австралийн Үндэсний их сургуулийг олон улсын эрх зүйч мэргэжлээр төгссөн ийм хүн байна. Тэгээд Цогтбаатар гишүүнийг ХЗБХ-ны даргад нэрийг нь дэвшүүлж байна. Та бүгдийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Ц.Мөнх-Оргил:** Тогтохсүрэн даргад баярлалаа. Тогтохсүрэн даргаас асуух асуулт асуулттай гишүүд байна уу? Байхгүй байна. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу? Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны даргаар ажиллаж байсан Монгол Улсад Хүний эрхийг хамгаалах эрх зүйн байдлын тухай анхны хуулийг санаачилсан. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг. Цогтбаатар гишүүн маань ингээд ХЗБХ-ны даргад нэр дэвшиж байгаад дэмжиж байна. Ер нь Монгол Улс бол олон улсын хүний эрхийн гэрээ конвенцууд, хүүхдийн эрх хамгаалах бүх гэрээ конвенцууд нэгдэн орсон. Ази дахь ардчилал, хүний эрхийн гол бэлгэдэл улсын нэгд тооцогддог хэдий ч сүүлийн үед энэ тодорхой хүний эрхийн асуудлуудаар тэр дотор хүүхдийн эрхийн асуудлаар асар их зөрчил, эрх зүйн болон яаралтай шаардлагатай шинэ зохицуулалтууд хэрэгтэй байгаа. Энэ нөхцөлд манай ХЗБХ хүний эрхийн болон эрүүгийн тодорхой хуулиуд, хүүхдийн эрх, гэр бүл дэх эцэг, эхийн хамгаалалт, хүүхэд хамгааллын асуудлаар бас илүү анхаарах шаардлагатай байгаа. Тийм учраас Цогтбаатар гишүүндээ хандаж 2 санал хэлмээр байгаа юм.

1 дүгээрт нь энэ хүүхдийн эрх хамгаалахтай холбоотой асуудлаар ялын бодлогыг чангатгах зүй ёсны шаардлага байгаа. Тэгэхдээ ялын бодлогыг чангатгах асуудал дээр бид нар сэтгэлийн хөөрөл

болон бусад нийгэмд бол тодорхой юунд автахгүйгээр судалгаа шинжилгээ, тэгээд олон улсын сайн туршлага энэ тэрийг үндэслэж, маш нухацтай хэлэлцэх шаардлагатай байгаа. Тийм учраас энэ тал дээр бас таны байр суурь ямар байдаг вэ?

2 дугаарт нь Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар жил бүрийн ХЭҮК-ын хүний эрхийн тайлан илтгэлийг бол ХЗБХ хэлэлцэж, шаардлагатай бол нэгдсэн хуралдаанд оруулдаг байсан ийм зохицуулалттай байгаа. Дэгийн тухай хуулийн 114.3, 114.2.12-т зааснаар. Ер нь бол Монгол Улс нэг хэсэгтээ буюу ойрын жилүүдэд хүний эрхийн асуудлаар бүх талын хамтын ажиллагаа анхаарах шаардлагатай. Тийм учраас Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд миний бие бол энэ ХЭҮК-ын илтгэлийг Байнгын хорооноос гадна Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцдэг байх нь илүү үр дүнтэй болон бусад хууль, эрх зүйг чангатгах шаардлагатай гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энэ тухай таны байр суурь ямар байдаг вэ? Ер нь бол энэ ХЭҮК-ын илтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэг байхаар бид нар энэ Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар байгаа юм. Энэ тал дээр та хамтран ажиллаарай гэж хүсэх байна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа асуулт асуучихлаа. Цогтбаатар гишүүн хариулах уу? Цогтбаатар гишүүний микрофоныг өгчихье.

**Д.Цогтбаатар:** Ер нь бол хүний эрхийн асуудал бол аливаа нийгмийн тасралтгүй анхаарч явж байх асуудал л даа. Тийм учраас энэ жишээлбэл хүүхдийн асуудал бол бас нэлээн хурц асуудлуудын нэг байсаар ирсэн. Яг ингэж тэсрэлттэй юм гарч байж энэ рүү нийгмээрээ, бүгдээрээ анхаарч байж явж байна л даа. Харамсалтай байна, уг нь ийм асуудлууд байгаад л байсан байхгүй юу. Би өөрийнхөө жишээлбэл дүүрэг дээр яг судалгаа хийгээд үзсэн чинь хамгийн гайхалтай нь Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар хотын хамгийн төвийн юу дүүрэг хэр нь энэ гэр бүлийн хүчирхийлэл, тэр чинь хамгийн түрүүн хүүхдүүдэд очиж бууж байдаг байхгүй юу. Гэр бүлийн хүчирхийлэл хамгийн их нэмэгдсэн 2 газрын нэг нь, нэг нь нэг хөдөөгийн аймаг байсан, нөгөөдөх нь Сүхбаатар дүүрэг байсан байхгүй юу. Хотын хамгийн төвийн дүүрэг. Тэгээд энэ дээр би бүүр тодорхой арга хэмжээ авч энд юу төсөл хэрэгжүүлж энийг анхаарах юм сан гээд энэ саяын гарсан сэтгэл цочирдуулсан асуудал гарахаас өмнө энэ дээр анхаараад явж байсан.

Тэгэхээр харин энэ дээр тэр ялын бодлогыг чангатгаад л зогсож болохгүй. Өөрийн чинь хэлж байгаа яг үнэн. Энэ дээр маш өргөн хүрээний судалгаа хийж байж, олон асуудлын давхцал дээр энийг шийднэ. Түүнээс ганц ялын бодлогоор энийг шийднэ гэж бодож байгаа бол дэндүү хялбаршуулсан, хүнд асуудалд хялбар шийдэл хайх гээд байна гэсэн үг. Тэгэхээр тэр сэтгэлийн хөдлөлөөр үнэхээр хандаж болохгүй гэдэгт бол би санал нэг байна. Наад зах нь энд яригдаж байхад сэтгэл зүй судлалын талаар ялангуяа криминологийн сэтгэл зүй судлалын талаар энэ эрүүгийн гэмт хэрэгтэй холбогдсон энэ асуудлаар сэтгэл зүйн судалгаанууд, энэний дүгнэлт үнэлгээ гаргадаг энэ тогтолцооны тухай хэн ч ярихгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхэд нийгэмд бүхэлдээ сэтгэл зүйн ямар өөрчлөлтүүд орчихсон байгаад байна, энийг яаж шийдэх вэ гэдэг энэ асуудлыг бол би анхаарах ёстой. Тэгэхээр энд бол цогц, системтэй хандлага хэрэгтэй, судалгаатай хандлага хэрэгтэй гэж гэж бодож байгаа.

2 дахь өөрийн чинь тэр ярьсан чуулганаар Хүний эрхийн Комиссын энэ илтгэлийг хэлэлцүүлэх дээр бол би бол дэмжиж ажиллана. Тэгээд энэ дээр бас мэдээж Их Хурал өөрөө л шийднэ. Их Хурлынхаа түвшинд гишүүдтэйгээ ярьж байгаад шийдэх байх гэж бодож байна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Тодруулах уу, болсон уу? Болсон байна. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны даргад нэр дэвшигчтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Сүхбаатар гишүүнд микрофон өгье.

**Ж.Сүхбаатар:** Цогтбаатар дарга ХЗБХ-ны даргаар ингээд сонгогдоод явна. Тэгэхээр эхлээд тулах асуудлууд бол нэлээн олон хуулиуд байгаа л даа. Жишээлбэл миний ахалж байгаа Зөрчлийн хууль байгаа. Тэгэхээр энэ Зөрчлийн хуулийн агуулгыг бол нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, Зөрчлийн эсрэг хууль гэдэг философиор явуулах шаардлага байгаад байгаа. Засгийн газар удахгүй хэд хэдэн хуулийн төслүүд оруулж ирэх байх. Тэгэхээр энэ дээр бас Байнгын хорооны дарга анхаарлаа хандуулж ажиллахыг хүсье.

2 дахь нь бол Цогтбаатар даргын хувьд бол олон улсын эрх зүйн чиглэлээр туршилагатай, мэдлэгтэй ийм хүн. Тэгэхээр Хууль зүйн шинэ сайдаар томилогдсон Энхбаяр ч гэсэн хүний эрхийн мэдрэмжтэй бодлого явуулна гэж байгаа. Тэгэхээр юун түрүүн манай энэ намрын чуулганыхаа асуудлууд дээр яг хуулийн энэ асуудлыг Шүүх байгуулах тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн гээд байгаа энэ олон хуулиуд дээр яг энэ заалтууд дээр бас Цогтбаатар даргыг бол энэ дээр нэлээн анхаарал хандуулж, олон асуудал хэлэлцэх асуудлууд бидэнд байгаа ч гэсэн энэнийхээ эрэмбэ ач холбогдлыг энэ нь анхаарах байх гэж ингэж бодож байна. Тэгээд ХЗБХ-ны ирэх долоо хоногийн хуралд юу, ирэх долоо хоногийн хуваарьт ч гэсэн тэр манай ажлын хэсэг эд нарыг бас оруулчхаарай.

Өөрт чинь бол манай Байнгын хороонд байгаа энэ олон гишүүд байж байна, тусалж дэмжээд ажиллачихна. Туршилагын хувьд бол ярих юм бол байхгүй өөрт чинь. Хамгийн гол хэлэх юм бол олон улсын байгууллагуудтай энэ цаг үе амаргүй байгаа үед бол манай нөхцөл



байдлыг зөв ойлгуулах ёстой. Өмнөх сайд Хууль зүйн сайд байсан Нямбаатар маань бол нэлээн Трансперенси интернешнлын чиглэлээр бусад чиглэлээр бол нэлээн идэвхтэй ажиллаж байсан гаднынхантай. Тэгэхээр энэ асуудал дээр бол манай шинэ Байнгын хорооны дарга бол би бас нэлээн түлхэц дэмжлэг үзүүлэх байх гэсэн ийм бодолтой байгаа. Тэгээд ажилд нь бол амжилт хүсье. Тэгээд хэд хэдэн гол чухал хуулиуд байгаа. Энэ дээр бол идэвхтэй хамтран ажиллана гэдгээ өөрт чинь бас хэлье гэж бодож байна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Гишүүд уг хэлж дууслаа. Санал хураалт явна. Гишүүдээ суудлаа эзлээрэй. Санал хураалт явууллаа шүү. ХЗБХ-ны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатарыг нэр дэвшүүлснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт явагдаж, 100 хувийн саналаар санал дэмжигдлээ. Цогтбаатар гишүүнд баяр хүргээд, ажлын амжилт хүсэн ерөөе. ХЗБХ-ны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. ХЗБХ-ны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг танилцуулна.

12.40 цаг

**Хоёр. Сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл**

Дараагийн асуудалдаа оръё. Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл байна. Хүний эрхийн дэд хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг нарын Ц.Мөнхцэцэг нарын 20 гишүүн, мөн Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан нарын 17 гишүүдээс Хүүхдийн эрхийг хамгаалах, хангах асуудлаар, Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг зохион байгуулах тухай хүсэлтийг Улсын Их Хурлын даргад

ирүүлсэн байна. Тогтоолын төслийг та бүхэнд танилцуулсан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Асуулт байна уу гишүүдээ? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Сүхбаатар гишүүн, Бямбацогт гишүүн. Бямбацогт гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

**Ж.Сүхбаатар:** Өнөөдөр Охидын эрхийг бас хамгаалах олон улсын ийм өдөр тохиож байна. Тэгээд сая өнгөрсөн хугацаанд ч гэсэн бидний хувьд бол сэтгэл хиртхийлгэсэн хүний эрхтэй, хүүхдийн эрхтэй холбоотой асуудлууд бас удаа дараа хөндөгдөж байгаа. Нийгмийн бас нэг ийм хөндүүр сэдэв болж байгаа. Тэгээд энэ сонсголыг манай Мөнхцэцэг гишүүн удирдаад явуулах юм байна. Тэгэхээр гол юм бол яах вэ яриад л байна. Тэгээд юм хийгээч дээ гэнэ Тэгээд бас ярихгүйгээр, хэлэлцэхгүйгээр, ойлголтоо нэгтгэхгүйгээр, оюун бодлоо нэгтгэхгүйгээр бол асуудлыг бас зөв шийдэж чадахгүй. Тэгэхээр нийгмийн хүрээнд бухимдал бол байна, шүүмжлэлүүд байна. Тэгэхдээ бухимдал, шүүмжлэлээр 1 далайлтаар гэдэг юм уу, 1 том шийдлээр бол шууд шийдэхгүй. Ер нь бол бид нарын энэ цочоод ямар нэгэн том алхмууд хийнэ гэхээр дандаа 1, 2 далайлтаар уг үндсээр нь шийднэ гэж ойлгодог.

Яг үнэндээ бол уг үндсээр нь шийднэ гэх юм бол бэлтгэл ордог, судалгаа ордог, төлөвлөлт ордог, гүйцэтгэлд хугацаа ордог. Энэний хамгийн гол Монголын нийгэмд байгаа хамгийн гол хэцүү асуудал бол тэр ойлголцол байгаа юм. Оюун бодлоо нэгтгэх. Яг оюун бодол үнэхээр нийлээд, нэгдээд байгаа юм бол тэр арга хэмжээгээ хэрэгжүүлэх, тайлбарлан таниулах дээр бүгд нэгдмэл болох ёстой. Нэг нь нөгөөгөө хүлээж биш. Тэгэхээр энэ сонсголыг явуулахдаа бол би гол юм нь бол

хэдэн гишүүд ингээд тойроод юм уу, мэргэжлийн хүмүүс хэлээд зогсохгүй, тэр олон нийтийн оролцоог мэдээлэл хүргэх, тэр санал шүүмжлэлээ тэрэн дээр оролцоог яаж бий болгох вэ гэдэг дээр их анхаарах ёстой байх.

Тэгээд ер нь бол энэ бухимдал, шүүмжлэлийн чинь цаана ажил явахгүй байна гэсэн л санаа хэлээд байгаа шүү дээ. Тэгээд л ярихад эсвэл мөнгө төсөв мөнгө нь бага байна гээд л ярьдаг, эсвэл тэрийг нь үр ашигтай зарцуулсангүй гээд л ярьдаг. Тэгээд энэ болгон дээр миний хувьд бол энэ хяналтын сонсгол бол зорилго нь юу юм бэ гэхээр зэрэг хууль тогтоомжийн эрх зүйн орчин ямар байгаа гэдэг нэг асуудал байгаа. 2 дугаарт бол бодит ажлууд ямар байгаа гэдгээ бол.

Нөгөө нэг гол асуудал бол бидний өөрсдийн маань ойлголт ер нь нэгдмэл байгаа юм уу үгүй юу гэдгээ л ер нь харуулах хэрэгтэй. Бид нар чинь дандаа зөрчилдөөд, ялгаатай байдлаа хүн болгон харуулахыг л хичээгээд байгаа юм. Бид нарын тэгвэл нэгдэж байгаа асуудлууд нь яг юу юм бэ гэдгийг нь бол энэ сонсгол байна уу, бусад асуудлууд дээр ер нь нэг тодорхой болгомоор юм байна лээ. Нэгдэж байгаа асуудлууд нь яг хоорондоо ойлголцоод ийм ажил хийх ёстой юм байна, энэ асуудал нь ийм юм байна гэдэг ойлголт нь нэгдээд, ойлгогдоод ингээд болоод ирж байгаа цагт бол тэрэн дээрээ төвлөрдөг баймаар байгаа юм. Тэгэхгүй одоо ингээд байдлыг нь ингээд харахаар бол заавал ингээд нөгөө ялгаатай тал дээрээ төвлөрөх, нэг нь нөгөөгөө шүүмжлэх эсвэл үгүйсгэх энэ нөхцөлд ингэж мэдээллээ ашиглах гэдэг юм уу, мэдээллээ түгээх гэдэг юм уу, энийгээ илүү их анхаараад байгаа юм.

Тэгэхээр энэ хүүхдийн эрхийн асуудал бол хүн болгоны нийтлэг ийм ашиг сонирхол нэгдэж болох ийм угаасаа асуудал учраас нэг их улс төрийн асуудал гэхээс илүүтэй нийгмийн хурц хөндүүр асуудал. Тэгэхээр энэ сонсголын асуудал

маань 10 дугаар сарын 25-ны өдөр гээд ингээд тавьчихаж. Тэгэхээр энэ дээр маш их санаа зовж байгаа, тэр шүүмжлэлтэй улсуудыг татан оролцуулахаас гадна тэр хүмүүст энийг дуу бодлоо илэрхийлэх тэр боломжийг нь яаж хангах вэ гэдэг дээр би бас сонсголоо анхаараарай. Яг л явж ирсэн энэ сонсголууд шиг болчихлоо гээд. Ер нь манай тэгэхдээ Их Хурлын үйл ажиллагаанд чинь юм сайжраад л байгаа шүү дээ. Бас энэ сонсгол чинь огт оролцоогүй байсан оролцоонууд нэмэгдээд л байна. Одоо яах вэ шүүмжлэл нь юу байна вэ гэхээр зэрэг дандаа хүрээг нь өргөтгөх, илүү гүнзгий асуудлуудыг авч үздэг байх гэдэг юм уу, дараагийн чанарын шаардлага тавьж байгаа болохоос биш, энэ Монгол Улсын энэ 2020 онд байгуулагдсан Их Хурал бол өмнөх парламентуудаас илүү их тийм сонсгол хийдэг соёлоо нэлээн нэвтрүүлж байгаа ийм Их Хурал гэж хэлж болно. Нэлээн нээлттэй болж байгаа.

Тэр утгаараа бол хүмүүс ганцхан фэйсбүүк дээрээ, цахим хуудсан дээрээ санаа зовоод байдаг биш ард түмний төлөөллийн байгууллага парламент дээр энэ нь бол албан ёсоор нэлээн тодорхой сэдвүүд дээр зангидагдах ёстой бас. Ингээд хаа хамаагүй биш. Тэгэхээр гол энэ сонсголын чинь гол юм бол тэр шүү дээ. Бодлого юу юм, төсөв хөрөнгө санхүүжилт нь юу юм, тэгээд удирдлага зохион байгуулалт нь юу юм төр талаасаа. Ийм талд нь бол илүү их л төвлөрч ярьдаг ийм онцлогтой. Тэгээд энэ асуудал дээрээ цаашаа анхаараад явна биз гэж. Ингээд ямар ч байсан энэ сонсголын үйл ажиллагаа өнөөдөр Охидын эрхийг хамгаалах өдөртэй таарч байгаа учраас хүн болгон хүний эрх хамгаалагч байхаасаа гадна, хүүхдийн эрхийн төлөө бол ер нь бол бүх эцэг, эхчүүд, бүх насанд хүрсэн хүмүүс өөрсдөө оролцогч байж энэ эрхийг хамгаалах, хангах ажлыг хийнэ. Тийм учраас нэг нь хамгаалагч, нөгөөдөх нь шаардагч бол энэ асуудал дээр бол биш. Бүгд оролцогч нэг тал байх ёстой гэсэн ийм л бодолтой явдаг хүн. Тийм учраас энэ сонсголын ач холбогдол бол өнөөдөр



бол би цагаа олсон ийм байгаа учраас 2 талын гишүүд маань хүмүүсээ зохион байгуулалтаа сайн хангаж оролцох биз гэж хэлэх байна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа санал хэллээ. Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Энэ хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар хяналтын сонсгол хийх гэж байгааг дэмжиж байгаа. Бас урьд урьд нь бас олон сонсголууд хийгдэж байгаа. Зарим сонсголууд маань бас олны анхаарал татчихсан бас тодорхой бас асуудлыг шийдсэн, үр дүн гарсан тийм сонсгол болдог. Зарим сонсголууд маань бас нэг тийм хэлбэрийн төдий сонсгол болоод өнгөрчихдөг. Тийм болохоор яах аргагүй бас олныг хирдхийлгэсэн, олон нийтийн зэвүүцэл бухимдал төрүүлсэн энэ бас тийм ээ, ялангуяа хүүхдийг хүчирхийлсэн иймэрхүү асуудал гарч байгаа үед бол энэ асуудлыг хэлэлцээд явах нь зөв байх.

Улсын Их Хурал, бас ЗГ-аас ч гэсэн бас Эрүүгийн хуульд бас тодорхой хуулийг чангатгах, хүчин болон гэр бүлийн хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар нэлээн хууль чангалсан хуулийн төслөө ойрын үед бас өргөн барих гэж байгаа. Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн бас эмэгтэй гишүүд маань ялангуяа оролцоод Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл санаачилж Их Хурлаар бас хэлэлцүүлэх гэж байгаа юм байна лээ. Тэгээд энэ сонсгол, энэ өргөн барих гэж байгаа хуулиудын хоорондын бас уялдаа холбоог хангах, энэ сонсгол бид хуулиа баталчхаад ард нь сонсгол хийх үү, уул нь бол энэ хуулиудыг хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг шийдчихээд, сонсголоо хийгээд, сонсгол дээрээсээ олон нийтийн оролцоог сайн хангаж байж, иргэдийн мэдэх эрхийг хангах, олон нийтийн оролцоог хангах, гарцаа байхгүй одоо бас нийгэмд тулгамдсан асуудлууд юу байна, тэр яг асуудлуудыг шийдэхэд ялангуяа хүүхдийн эрхийг хангахад төрийн үүргээс гадна тийм үү, олон нийтийн

байгууллагын оролцоо, олон нийтийн хяналт, бас тэр тийм сургуулийн болон бас бас орон сууц, байр, гэр орны орчин энэ зэргийн, яаж цахимжуулах юм, камертай хяналтыг камертай болгох уу гэх мэтийн олон асуудал хөндөгдөх байх.

Гэхдээ хамгийн гол нь бас нэг гол юм бол энэ эцэг, эхийн үүрэг. Хүүхэд бол өөрөө юу гэдэг юм гэр бүлээ сонгож төрдөггүй. Хаана ч, хэний ч, ямар ч орчинд төрсөн өссөн бай, төрсөн бай тэр хүүхэд эрхтэй байх ёстой. Гэтэл эцэг, эхийн үүрэг оролцоо, гэр бүлийн үүрэг хариуцлага гэдэг юм тэгээд үүнээс болж хүүхдийн эрх зөрчигддөг. Ерөөсөө л хүүхэд төрүүлээд л байдаг, эцэст нь хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх, хүүхдээ харж хандах, хооллох, хувцаслах гэдэг асуудалд анхаарал тавьдаггүй гэдэг юм уу тиймэрхүү юмнууд бас нийгэмд бас их байгаа. Яригддаг, яригддаггүй. Тэгээд энэ талаас нь бас сонсгол зохион байгуулахад илүү анхаараасай. Ерөөсөө л төрийг буруутгадаг, төрийн байгууллагууд, албан тушаалтныг буруутгадаг байдлаас биш тийм үү, эцэг, эхчүүд маань өөрсдөө бас тийм хараа хяналтаа сайжруулах, эцэг, эхчүүд нь бас хүүхэд төрүүлсэн юм бол тэр төрүүлсэн хүүхдийнхээ төлөө бас анхаарал халамж тавьдаг байх энэ талаас нь бас жоохон бодолцох талаас нь бас сонсгол зохион байгуулахдаа бас анхаараасай гэж 1 дүгээрт нь хэлье.

2 дугаарт нь түрүүн бас хэлсэн. Энэ Их Хурлаар өргөн барих гэж байгаа, Их Хурлаар хэлэлцэгдэх гэж байгаа энэ хуулиудтай хэрхэн яаж уялдуулах вэ? Цаг хугацааны хувьд яаж уялдуулж, холбоотой бол хийх вэ? Тэгэхгүй баахан хуулиуд хэлэлцээд, баталсныхаа дараа сонсгол хийх юм бол ямар ч үр дүнгүй болчихно. Тийм болохоор энийг бас уялдуулах тал дээр бас манайхан, ХЗБХ болон сонсгол зохион байгуулах улсууд бас анхаарч ажиллаарай л гэдгийг хэлье. Өөр зүйлгүй.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Мөнхцэцэг гишүүн сонсгол зохион

байгуулах үедээ гишүүдийн хэлсэн саналыг анхааралдаа авна биз тийм ээ. Сая гишүүд их чухал санаа хэлээд байна шүү дээ. Тэр эцэг, эхийн үүрэг роль энэ тэр гээд. Тэгээд энэ чинь нээрээ ингээд л нэг цонхоо онгойлгочихсон, машиныхаа look-ээр 2 хүүхдийнхээ толгойг цухуйлгачихсан, тэгээд л хар хурдаараа 60, 70 км-ийн хурдтай давхиад л байдаг. Тэгээд нэг бодлын хүүхдээ эрхлүүлж байгаа. Нөгөө талаас энэ чинь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулж байна шүү дээ тийм ээ. Тэгээд тэр чинь хуулийн заалттай байх ёстой. Замын хөдөлгөөний дүрэм биш шүү дээ наадах чинь, бусдын амь насанд аюул учруулж байна гэдэг зүйл ангитай байх ёстой шүү дээ гэх мэтээр энэ хуулийн төсөл хэлэлцэх үед анхаарна биз. Сонсголын үед ч гэсэн анхаарна биз дээ.

Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслөөр санал хураана. Тогтоолын төслийг танилцуулъя уншиж.

Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14, Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.4, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1, 119 дүгээр зүйлийн 119.1, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ХЗБХ-ноос тогтоох нь:

1. Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар хяналтын сонсгол явуулах хугацааг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2. Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой хяналтын сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэгийг сонгосугай.

3. Сонсгол зохион байгуулах бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар Өлзийсайханд даалгасугай. ХЗБХ-ны дарга гэсэн байна. Тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 90 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.52 цаг

Байнгын хороо хэлэлцэх ёстой 2 асуудлаа хэлэлцэж дууссан учраас өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөж байна. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

